МОНГОЛ УЛС
**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГА**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-3603
E-mail: info@bo.gov.mn
http://www.bayan-olgii.gov.mn/

2022.11.28 № 1-01/1603

**танай__________-ны №__________-т**

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, тус аймгийн Засаг даргын хооронд байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний биелэлт болон 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгах саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ..... хуудастай.

ЗАСАГ ДАРГА Д.БАУЫРЖАН

0105223083

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах № "22-02" дугаар гэрээний нэгдүгээр хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2022 ОНД БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2022.11.28

| № | № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Санхүүжилтийн эх үүсвэр /сая.төг | Шалгуур үзүүлэлт /тоо хэмжээ/ | Суурь түвшин | Хүрэх үр дүн | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. **Байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах** | | | | | | | | |
| 1 | 1 | Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах | 2.0 | 12 удаагийн хяналт шалгалтад 12 сумыг хамруулна | 2021 онд 8 удаагийн хяналт шалгалт зохион байгуулсан. | 12 удаагийн хяналт шалгалтыг суманд зохион байгуулж, байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчил 5 %-иар буурсан байна. | Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран Ховд голын сав газрын дагуух Алтанцөгц, Бугат, Ногооннуур сумдын ойн сан бүхий газруудад хүрээлэн буи орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гаргахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах, хяналт шалгалтын ажлыг 6 удаа зохион байгуулав. Хууль бус түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газруудтай хамтарсан сарын аяныг зохион байгуулж аяны хугацаанд хууль бус хайрга олборлосон 5 иргэнийг илрүүлж хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллав.<br>Хөх Сэрхийн нурууны хамгаалалтын захиргааны зүгээс давхардсан тоогоор төлөвлөгөөт хяналт шалгалтыг 48 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 71, гүйцэтгэлийн шалгалтыг 51, урьдчилсан хяналт шалгалтыг 45 удаа, хамтарсан хяналт шалгалтыг 5 удаа, нийт давхардсан тоогоор 220 удаа хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газраас давхардсан тоогоор төлөвлөгөөт хяналт шалгалтыг 127 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 79, гүйцэтгэлийн шалгалтыг 59, урьдчилсан хяналт шалгалтыг 121 удаа, хамтарсан хяналт шалгалтыг 8 удаа, нийт давхардсан тоогоор 386 удаа хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Хяналт шалгалтын үр дүнд 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэмийг зөрчиж зөвшөөрөлгүй байшин барьсан 3 зөрчлийг тус тус илрүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хариуцлага тооцон, нийтдээ 3 иргэнд 1 500 000 төгрөгийн торгууль оногдуулж, торгуулийг бүрэн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | барагдуулж, зөрчлийг арилгуулав. Мөн хууль бусаар мод бэлтгэсэн 3 зөрчлийг илрүүлж, 2 зөрчилд нь зөрчлийн хэрэг нээж шалган, хүн тус бүрийг 300 000 төгрөгөөр торгож, 2 302 140 төгрөгийн нөхөн төлбөрийг оногдуулан бүрэн барагдуулав. Нэг зөрчил нь гэмт хэргийн шинжтэй тул харьяаллын дагуу аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэв. Сийлхэмийн нурууны байгалийн цогцолборт газрын “Б” хэсэгт 2020, 2021 онуудад үйлдэгдсэн зөрчлүүдийг арилгуулах ажлыг зохион байгуулж, зөвшөөрөлгүй баригдсан 2 байшин, 3 тооны малын хашаа хороог шүүхийн шийдвэрээр албадан буулгуулав. | |
| 2 | 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх | 12.5 | Аймгийн БОАЖ-ын газрын 5 байгаль хамгаалагчдыг мотоциклээр хангана | 2021 онд 4 байгаль хамгаалагчийг мотоциклээр хангасан | -Албан хаагчдыг 2 удаагийн сургалтад хамруулсан байна.<br>-5 тээврийн хэрэгслэлээр хангасан байна.<br>-44 хүнийг 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. | Байгаль орчны салбарт ажиллагсадын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор Аймгийн Засаг даргын 2022 оны А/267 дугаартай захирамжаар 12.5 сая төгрөг шийдвэрлэн Баяннуур, Ногооннуур, Толбо, Цэнгэл сумын байгаль хамгаалагчдыг унаагаар /мотоцикль/ хангав.<br>Албан хаагчдыг 6 удаагийн сургалтад хамруулсан байна / УБ хотод 8 албан хаагч орон нутагт 44 албан хаагч танхим болон цахимаар сургалтанд хамрагдсан / Баруун бүсийн байгаль орчны салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн “олуулаа нэгдэж асуудлаа шийдье” чуулга уулзалтанд тус айгаас байгаль орчны салбарт ажилладаг 50 гаруй эмэгтэй албан хаагч нар хамрагдсан.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилсан “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аян Монгол орон даяар өрнөж байгаа билээ. Уг аяны хүрээнд “Эртэч, Эерэг, Эрүүл Баян-Өлгийчүүд” уриан доор байгууллагын албан хаагч нарыг хамааруулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 44 албан хаагчийг 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. | 100% |
| 3 | 3 | Байгаль орчны хамгаалах нөхөрлөлүүдийг тодорхой дэмжлэг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион байгуулах | 3.0 | 47 Байгаль орчны нөхөрлөлүүдийг хамааруулна. | - | Нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа дэмжигдсэн байна -47 | “Нутгийн иргэдэд түшиглэсэн зэрлэг амьтны хамгааллын менежментийг хэрэгжүүлэх нь” баруун бүсийн зөвлөгөөн зохион байгууллаа. Уг зөвлөгөөнийг “Монголын ан агнуурын холбоо”-той хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээнд МУИС, ХААИС-ийн профессор, багш нар, “Монголын ан агнуурын холбоо”-ны тэргүүн, “Аргал агнуур судлалын төв”-ийн тэргүүн бусад ан агнуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага болон сумдын удирдлага, байгаль хамгаалагч, ан амьтан хамгаалах нөхөрлөлийн нийт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 110 гаруй хүн оролцов. | |
| 4 | 4 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны зардлаар | -Ойн нөөц ашигласны төлбөрийн 85%<br>-Газар ашигласны төлбөрийн 15 %<br>-Ан амьтны ашигласны төлбөрийн 50 %<br>-Ус зашаан ашигласны төлбөрийн 35%<br>-Байгалийн ургамал ашигласны 15 хувийг Байгаль орчныг хамгалаах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ажлыг зохион байгуулах | -Ойн нөөц ашигласны төлбөр 33.236.425 төгрөг<br>-Ан амьтны нөөц ашигласны төлбөр 1,065,321,695.28 төгрөг<br>-Хог хаягдлын хураамж 2,778,800.00 төгрөг<br>-Ус рашаан ашигласны төлбөр 1,822,034.00 төгрөг<br>-Газрын төлбөр 58,729,067.00 төгрөгийн орлого орсон байна. | -Ан 770 сая төгрөг<br>-Ойн нөөц 40 сая төг<br>-Ус рашаан 20 сая төг<br>Газар 320 сая төгрөгийн төлбөрийн орлогыг бүрдүүлнэ.<br>2022 онд 120 сая төгрөгийг байгаль орчныг хамгалаах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна.<br>Хуулийн хэрэгжилтийг 70-аас доошгүй хувьд хүргэнэ. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн чуулганаар орон нутгийн төсвөөс 249.0 сая төгрөгийг байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд тусгуулан үүнээс зэрлэг ан амьтдад зориулан биотехникийн арга хэмжээ авах, мод тарьж ойжуулах, ногоон байгууламж бий болгох зэрэг арга хэмжээнд зарцуулан ажиллав.<br>БОАЖЯам болон НҮБХХ-ийн Биологийн олон янзын байдлын санхүүжилтийн санаачилгаа-II төсөлтэй хамтран Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчилэн баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” хавсралт маягтыг гаргахтай холбоотой асуудлаар сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт цахим сургалт зохион байгуулж, 2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, зарцуулалт болон 2022 оны давсан орлогыг хууль журмын дагуу зарцуулах талаар мэдээллийн санд бүрэн оруулж ажиллав. | 100% |
| 5 | 5 | Байгаль орчин аялал жуулчлалын газрын веб сайт, цахим мэдээллийг шинэчлэх | 0.5 сая | БОАЖГ-ын веб сайт, цахим мэдээллээр ил тод байдлыг хангаж ажилласан байна. | - | Байгаль орчны салбарын сурталчилгааны ажил сайжирсан байна. | Орон нутгийн төсвөөс 0.5 сая төгрөг зарцуулан аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар http://nature.bo.gov.mn веб сайт нээж, Нийтийн мэдээллийн ил тод байдын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 заалт, Монгол улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 1/2673 дугаар зөвлөмжийн дагуу холбогдох мэдээллийг бүрэн оруулж, тогтмол ажиллуулж байна. | 100% |
| 6 | 6 | Мэдээллийн санг сайжруулах (eic.mn) | Үйл ажиллагааны зардлаар | Журмын хэрэгжилтийг хангаан ажиллах | 2021 онд БОХ-1-10 маятыг бүрэн оруулсан байна | БОАЖЯамны мэдээлэлийн санд мэдээллийг бүрэн оруулсан байна. | БОХ-1-10 маятуудын дагуу холбогдох мэдээллүүдийг сум дундын Ойн анги болон сумдын байгаль хамгаалагч нараас тухай бүр гаргуулан авч, хугацаанд бүрэн оруулан ажиллав. | 100% |
| 7 | 7 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах процессыг цахим системд шилжүүлэх | - | Цахимаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний | 2021 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний 233 дүгнэлт гаргаж, | Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 166 иргэн, аж ахуйн нэгжийн төслийн баримт бичигт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж мэдээлийн санд оруулан ил тод байдлыг хангаж ажиллаж байна | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүгнэлтээ гаргуулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тоо | Мэдээллийн санд оруулав | процессыг цахим системд шилжүүлсэн байна. | | |
| 8 | 8 | Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтран баталсан 2006 оны 342/ 366 дугаар тушаал “Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд урамшуулал олгох журам”-ын хэрэгжилтийг хангах | | Урамшуулсан байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчийн тоо, төлбөрийн орлогоос урамшуулсан хувь хэмжээ | Сангийн сайд, Байгаль орчны сайдын 2006 оны 342/366 дугаар тушаалын хэрэгжилт хангалтгүй | Аливаа зөрчлийг илрүүлсэн буюу ноцтой зөрчлийн талаар цаг үе олсон бодитой үнэн зөв, тодорхой мэдээлэл илрүүлсэн иргэнд торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15%-тай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон байна. | Аливаа зөрчлийг илрүүлсэн буюу ноцтой зөрчлийн талаар цаг үе олсон бодитой үнэн зөв, тодорхой мэдээлэл илрүүлсэн иргэнд торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15%-тай тэнцэх мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулан ажилллаж байна. / иргэд мэдээ мэдээлэл өгөөгүй болно. / | 70% |
| 9 | 9 | “Иргэн бүр байгаль хамгаалагч” уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх | | Шинээр байгуулагдсан байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн тоо<br>Шинээр нэмэгдсэн идэвхитэн байгаль хамгаалагчийн тоо | - | Байгаль орчныг хамгаалж, үр шимийг хүртэх зорилгоор иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэн нөхөрлөж, үр дүн гаргасан байна. Идэвхитэн байгаль хамгаалагчийг нэмэгдүүлсэн байна. | Тус аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 67 нөхөрлөл, 111 идэвхтэн байгаль хамгаалагч үйл ажиллагаа явуулж байна.<br><br>2022 онд шинээр 8 иргэнд идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх олгон хамтарч ажиллаж байна. | 100% |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | **96.6%** | |
| **2. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах** | | | | | | | | |
| 10 | 1 | “Хандлагаа өөрчилье” уриа бүхий “Ногоон паспорт” аяныг ерөнхий боловсролын сургуулиудыг хамруулан хэрэгжүүлэх | Орон нутгийн төсөв | Бүх сумд | 2021 онд ковид-19 тахлын улмаас хойшлогдсон. | Эко клубын сурагчдын чуулга уулзалт зохион байгуулсан байна | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Насан туршийн боловсролын төвтэй хамтарсан удирдамжийн дагуу 2022 оны 02 дугаар сарын 15-наас 04 дүгээр сарын 01-ний хүртэл “Эх дэлхийгээ хайрлая” аяныг зохион байгуулан ажиллаа. Аяны хүрээнд аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулиудад байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулж, сурагчдын дунд танин мэдэхүйн “АХА” тэмцээн, гар зургийн уралдаануудыг тус тус зохион байгуулж, амжилттай оролцсон сурагчдыг өргөмжлөл, мөнгөн шагнал, үнэ бүхий | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зүйлээр шагнаж урамшуулан ажиллаа. | |
| 11 | 2 | Байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээг орон нутагт сурталчлан таниулж, эко тэмдэг, ногоон гэрчилгээ бүхий орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дэмжин ажиллах | Орон нутгийн төсөв | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн аж, ахуйн нэгж байгууллагыг оролцуулсан сургалт, сурталчилгааны ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан байна. | | Аймгийн хэмжээнд эко тэмдэг, ногоон гэрчилгээ бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг сурталчлан таниулах чиглэлээр 2-аас доошгүй арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. | Байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээг орон нутагт сурталчлан таниулж, эко тэмдэг, ногоон гэрчилгээ бүхий орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг дэмжин ажиллах зорилгоор байгууллагын веб сайт болон орон нутгийн радиогоор сурталчилгааны ажлыг зохион байгуулав.<br>Байгаль орчны багц хууль сурталчлах зорилгоор Алтай, Алтанцөгц, Толбо, Дэлүүн, Баяннуур, Буянт, Ногооннуур, Цагааннуур тосгоны ард иргэдэд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж, уг арга хэмжээнд нийт 400 гаруй ард иргэд оролцлоо. | 90% |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | **95%** | |
| 3. **Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах** | | | | | | | | |
| 12 | 1 | Аймгийн хэмжээний ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах | 40.0 | Мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-д батлуулсан байна. | 2018 онд хийгдсэн | Ангийн бүс нутгуудын менежментийн төлөвлөгөө батлагдсан байна. | Аймгийн ан агнуурын менежмент төлөвлөгөө орон нутгийн хөгжлийн сангийн нийт 60.0 сая төгрөгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн бөгөөд 2022 онд 40.0 сая төгрөгөөр холбогдох мэргэжлийн байгууллагар хийлгэж байгаа тухайн онд хийгдэх судалгааны ажлаа бүрэн хийсэн болно. | 90% |
| 13 | 2 | Зэрлэг амьтдад зориулж, биотехникийн арга хэмжээ авах | 8.0 сая | 21<br>Ангийн бүс нутгууд биотехникийн арга хэмжээ авна | Алтай сумын “Халуун бардам”, Ногооннуур сумын “Бахлаг”, Цэнгэл сумын “Мухар”, Сагсай сумын “Тургын”, Толбо сумын “Хоторжон”, “Борт”, гэх газруудад зэрлэг ан амьтад зориулан өвс, давс тавьж био техникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгууллаа. | Аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрсэн 6-аас доошгүй сумдын нутаг дахь зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авсан байна. | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 8.0 сая төгрөг зарцуулан Ногоонуур сумын “Бахлаг”, “Модон овоо”, Бугат сумын “Тошинт”, ”Хөшөөт уул”, Сагсай “Түргэн”, Толбо сумын “Хоторжон”, “Бургаст”, Улаанхус сумын “Хар уул”, Цэнгэл сумын “Мөст булаг” агнуурын ангийн бүс нутгуудад ховор амьтад зориулан давс тавих биотехникийн арга хэмжээ авах ажлуудыг зохион байгууллаа.<br>Алтай Таванбогдын БЦГ-ын Шивээтхайрхан, Сийлхэмийн нурууны ”Б” хэсэг БЦГ-ын Шивээт хайрхан, Хуурайт, Харгайт орчмын 6 цэгт 4 тн давс тавьж биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэв. | 100% |
| 14 | 3 | Хууль бус ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох хяналтыг эрчимжүүлэх | Орон нутгийн төсөв | Хяналт шалгалтын тоо | 2021 онд 3 “даа хяналт шалгалтын ажил зохион байгуулсан. | 2-оос доошгүй удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан байна. | Хууль бус ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох ажлын хүрээнд аймгийн Цагдаагийн газар, Мэргэлжийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтарсан сарын аяныг зохион байгуулж аяны хугацаанд хууль бус хайрга олборлосон 3 иргэнийг илэрүүлж, зөрчлийн тухай хуулийн дагуу 1 иргэний 200.000 төгрөгөөр | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | захиргааны арга хэмжээ авч ажиллав. | |
| 15 | 4 | Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх | ААН байгууллагын төсөв | 5 га -аас доошгүй талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. | - | Нөхөн сэргээлт хийсэн байна. | Мөн Бугат сумын нутаг дэвсгэрт иргэд хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон 8 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн. Улаанхус сумын нутаг дэвсгэрт зам ажилд зориулан түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон 2.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн. 2022 онд нийт 14.6 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн | 100% |
| 16 | 5 | "Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээний аймгийн дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах | Орон нутгийн төсөв | Ажлын хэсгийг үйл ажиллагааг хэвийн явуулах санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. | Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний биелэлт гаргасан. | Ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлсэн байна. | Аймгийн Засаг даргын А/570 дугаар захирамжаар байгуулагдсан аймгийн дэд ажлын хэсгийн дүнгээр уул уурхайн уулмаас эдэрсэн Булган сумын Их Жаргалантын "Бүркит корпараци" ХХК-ийн 24,3 га, Алтай сумын нутаг дэвсгэрт "Сагсайминерал ресурс" ХХК-ийн 5.2 га, Улаанхус сумын нутаг дэвсгэрт "Кайнарвальфром" ХХК-ийн 0.41 га Ногооннуур сумын Дулаанхарын "Юүшиминг" ХХК-ийн 6.4 га нийт 36.3 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэхээр Мэргэжлийн хяналтын газар, Экологийн цагдаагийн албанаас албан шаардлага хүргүүлнээс Алтай сумын нутаг дэвсгэрт 2.5 га, Улаанхус сумын нутаг дэвсгэрт 0.4 га, Ногоонуур сумын нутаг дэвсгэрт 0.8, нийт 3.7 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. | 100% |
| 17 | 6 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн 2022 оны БОМТ-д дүйцүүлэн хамгаалалын арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Орон нутаг | -Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ<br>-Байгуулсан хөв цөөрмийн тоо<br>-Тарьсан модны тоо | 1 аж ахуйн нэгж | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тусгасан байна. | Тус аймгийн Цэнгэл сумын нутаг дэвсгэрт далд уурхайн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхлүүлж буй "Эс жи групп" ХХК нь ашиглалтын талбайдаа 2000 ширхэг модыг тарьж арчилан ургуулж байна. | 70% |
| 18 | 7 | Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Аюултай хог хаягдлын төрөл, тоо хэмжээ | - | Аймгийн хэмжээнд аюултай хог хаягдлын тооллогыг зохион байгуулсан байна. | Аймгийн хэмжээгээр аюултай хог хаягдлын тооллогыг зааврын дагуу хийж, холбогдох дээд байгууллагад хүргүүлэв. Үүнд: 7636.2 тонн аюултай хог хаягдал тоологдсон ба хугацаа дууссан 33.4 литр шингэн, 7.9 кг хатуу бодис болон 9959 хоосон савыг аймгийн төсвийн 5.0 сая төгрөгөөр устгал хийлгэхээр мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. | 100% |
| 19 | 8 | Хог хаягдлын олон нийтийн байцаагч | - | Засаг даргын Захирамж | - | Журам батлагдсан | Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/497 дугаар захирамжаар "Хог | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам боловсруулж, батлах | | | | байна. | хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам"-ыг батлаж цаашид хэрэгжилтийг хангуулан ажиллах талаар сумдад чиглэл хүргүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа ба Алтанцөгц, Ногооннуур сумд Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажилуулж байна. | 100% |
| 20 | 9 | Ашиглалтад өртөн нөөц хомстож буй 1 зүйл ургамлын үрийн жишиг плантаци байгуулах | Орон нутгийн төсөв | 0.5га талбайд сармисан сонгино ургамлын үрийн плантаци байгуулах | - | Сармисан сонгино ургамлын үрийн плантаци байгуулсан байна. | Ашиглалтад өргөн нөөц хомстож буй Монгол Улсын улаан номонд орсон нэн ховор ургамал болох сармисан сонгино Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттаы газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалачтай хамтран 0.1 га газарт үрээр тармилжуулан үрийн плантанц байгуулан ажиллаж байна. | 100% |
| 21 | 10 | Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журам батлах | Орон нутгийн төсөв | Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх | - | Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон байна. | "Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журам"-ын төслийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэн хянуулав. | 70% |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | **93%** | |
| **4.Усны нөөцийн ашиглах, хамгаалах** | | | | | | | | |
| 22 | 1 | Булаг шандны эхийг хамгаалж, орчныг тохижуулах | 9.0 сая | 3-с доошгүй Булаг шандны эхийг хамгаалж, орчныг тохижуулснаар | 2021 онд Толбо, Дэлүүн, Булган сумдад булаг шандын эхийг хамгаалах, тохижуулалт хийгдсэн. | Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээгдэх боломж. бүрдүүлж булаг шандны эхийг хашиж орчныг тохижуулсан байна. | Орон нутгийн төсвийн 9.0 сая төгрөгөөр Ногооннуур сумын Хавцалын булаг, Алтанцөгц сумын Чихтэйн булаг, Баяннуур сумын Устын рашаан, орон нутгийн хөгжлийн сангийн 8.0 сая төгрөгөөр Баяннуур сумын 1 дүгээр багт булгийн эхийг тохижуулав. Мөн Буянт сум байгуулагдсны 80 жилийн ойн хүрээнд тус сумын нутаг дэвсгэрт 1 булгийн эх тохижуулах ажлыг төгсөгчдийн хандиваар хийж гүйцэтгэлээ. | 100% |
| 23 | 2 | Аж ахуйн нэгж, байгууллагад усны тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулах. | ААНБ-ын төсөв | Аймгийн хэмжээнд | 40 иргэн аж ахуйн нэгжүүдэд усны тоолууртой болгосон. | Хууль тогтоомжийн шийдвэр хэрэгжсэн байх | Аймгийн Засаг даргын 2022 оны А/176 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг тоолуурржуулах ажлыг зохион байгуулан ажилласнаар 2022 онд "Бес арыс" ломбард, Цагдаагийн газар, Залуучуудын ордон, Эрүүл мэндийн төв зэрэг 22 аж ахуйн нэгж байгууллага, 53 айл өрхийг тоолуурржуулах ажил хийгдсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | 3 | Ус бохирдуулагчийн тооллогыг сав газрын захиргаадтай хамтран явуулж, улсын усны мэдээллийн санд оруулах, холбогдох газарт тайлагнах. | ААНБ-ын төсөв | Аймгийн хэмжээнд | - | Улсын усны мэдээлийн санд бүртгэгдсэн байх | 2022 онд аймгийн хэмжээнд 481 ус бохирдуулагч аж ахуйн нэгж байгууллага тоологдож мэдээллийн санд бүрэн оруулав. | 90% |
| 25 | 4 | Аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт хязгаарлалтын бүсийг шинэчлэн тогтоож, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх | Орон нутгийн төсөв | Шинээр тогтоосон бүсийг хамгаалах, тэмдэгжүүлэх | 2021 оны аймгийн ИТХ-ын 6-р хуралдаанаар оруулж дэмжигдээгүй | Хуучин тогтоосон бүсийг шинэчилсэн эсэх | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдааны 118 дугаар тогтоолоор Өлгий сумын нутаг дэвсгэрт төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн хориглолтын бүсийг 100 метр, хязгаарлалтын бүсийг 500 метрээр тогтоолгон хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | 90% |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | **95%** | |
| **5.Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах** | | | | | | | | |
| 26 | 1 | Байгалийн нөөцийг хамгаалах ажлын хүрээнд Чигэртэйн голын ай савын БЦГ-ын тодорхой цэгүүдэд ан амьтны тооллогыг 2 удаа зохион байгуулж (төллөх үе, орооны үе) Биотехникийн арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | 2.0 | Чигэртэйн голын ай савын БЦГазар | Жилд 4-6 цэгт 8-10 удаа биотехникийн арга хэмжээг зохион байгуулж байна. | Тооллогыг 2 удаа зохион байгуулсан байна | Хөх Сэрхийн нурууны улсын тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргаанаас ан амьтанд зориулан Биотехникийн арга хэмжээг эхний хагас жилийн байдлаар нийт 6 цэгт 11 удаа авч хэрэгжүүлэв. Чигэртэйн голын ай савын БЦГ-ын халиун бугын идээшил нутаг болох Бураат уулын Шар жалга хэсэг, Төгрөг нуур салааны уулын ар хэсэг, аргаль хонины идээшил нутаг Нүцгэний ам, Улаан хөндий, Хүйтэн салаа, Ганц модны хэсэгт биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн, нийт 2.0 тн давс, 200 боодол өвс тавьж ажиллав. Биотехникийн арга хэмжээний үр дүнг хянах, ан амьтны шилжилт хөдөлгөөнд ажиглалт хийх зорилгоор дээрх 6 цэгт автомат камер байршуулж мэдээлэл цуглуулав. Чигэртэйн голын ай савын БЦГ-ын тодорхой цэгүүдэд ан амьтны тооллогыг зохион байгуулахад 4 дүгээр сард 186 аргаль, 10 дугаар сард 496 аргаль хонь тоологдсон. | 100% |
| 27 | 2 | Тусгай хамгаалалттай газар нутаг дахь үл хөдлөх соёлын дурсгалыг авран хамгаалах, гэмтэх, хулгайлагдахаас урьдчилан сэргийлэх ажлыг шат дараатай зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд, жилдээ 2 удаа | Аймагт байх үл хөдлөх соёлын дурсгалууд | Үл хөдлөх соёлын өвийн хамгаалалт сайжирч, хуулийн хэрэгжилт хангагдсан байна. Хэрэг зөрчил буурсан байна. | 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр орчны бүсийн Дэлүүн сумын ЗДТГ-тай хамтарч Чигэртэйн голын ай савын БЦГ-ын хязгаарлалтын бүсэд байгаа хүн чулууг үрэгдэж гэмтэхээс урьдчилан сэргийлж хашиж хамгаалах ажлыг зохион байгууллаа. Дэлүүн сумын ЗДТГ-ын 4 албан хаагч, хамгаалалтын захиргааны 3 албан хаагч оролцлоо. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 3 | Монгол Алтай Нурууны Улсын Тусгай Хамгаалалттай газарт ойжуулалт хийх | 3.0 сая | Тусгай хамгаалалттай газрууд хамаарна. | | Ойн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн байна. | Хамгаалалтын захиргааны ойжуулсан талбайн 3 га газарт 1000 бургасны суулгац нөхөн тарьж, усалгааны ажлыг сэргээсэн.<br>Мөн нөхөн сэргээлтэд зориулж 6000 тарьц суулган, 10 га газарт арчилгаа, цэвэрлэгээний ажил хийв. | 100% |
| 29 | 4 | Хамгаалах шаардлагатай, Экологийн хувьд ач холбогдолтой газар нутаг болох БЦГ-ыг өргөтгөх асуудлыг шийдвэрлүүлэх. | Үйл ажиллагааны зардлаар | Дэлүүн, Булган, Буянт, Улаанхус сумын нутаг дэвсгэрийн хамруулан 4 газрыг шинээр, 2 газрыг өргөтгөх аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг гаргуулсан байна. | - | Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Түвшин нуур, Тоошин, Цагаан хөндий, Тоошинт, Хар усны даваа, Булган сумын газар нутаг болох Булган голын эх (Гурван салаа), Ташуу уул, Хар нуур зэрэг газруудыг, Улаанхус сумын нутаг дэвсгэрт орших Олон нуурт орчмын газар нутгийг байгалийн нөөц газрын ангиллаар, Сийлхэмийн нурууны БЦГ-ын “А” хэсгийг Бага ойгор, Цагаан салаа зэрэг хадны сүг зургийн цогцолборыг оролцуулан өргөтгөхөөр, Буянт сумын нутаг дахь Зоо-Бөөрөгт-Эзэрлэгийн нуруу орчмын газар нутгийг БНГ-ын ангаллаар, Дэлүүн сумын нутагт орших Чигэртэйн голын ай сав орчмын газар нутгийг БЦГ-ын өргөтгөлөөр тус тус улсын тусгай хамгаалалтад авах аймгийн ИТХ-ын шийдвэрийг гаргуулж яаманд ирүүлсэн байна. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 5 өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч дэжигдээгүй тул “Зарим газрыг улсын тусгай хамгаалалтад авахаас татгалзах тухай” 62 дугаартай тогтоолыг аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 1-01/451 дугаартай албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уламжилсан. | 70% |
| 30 | 5 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд туссан улсын тусгай хамгаалалттай газар | Үйл ажиллагааны зардлаар | Тал нуур-Далайн хөх уул хөш сайн уул орчмын газар нутаг, Цэнгэл хайрхан-Цагаан асга, | | Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлгөөнд тусгаж хил зааг, | Аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Бугат сумын Өнчин толгой 8,6 га газар, Алтанцөгц сумын Цамбагарав уул 63 га газар, Улаанхус сумын Тахилгат толгой 0,59 га газруудыг аялал жуулчлалын түр буудаллах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нутгийн сүлжээг өргөтгөх газруудыг үе шаттайгаар хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж , ЗГ-ын 2018 оны 384 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах | | Чихэртэйн голын ай сав, Ачит нуур-Дэвэлийн арлын өргөтгөл, Ховд голын цутгал, Толбо нуур- Хүнгүй нуруу, олон нуур, сийлхэмийн нуруу Б өргөтгөл, Сийлхэмийн нуруу өргөтгөл А, Булган голын эх-Хар нуурууд бүхий газар нутгуудыг Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд улсын тусгай хамгаалалтад авах сүлжээ өргөтгөх газар нутгаар тусгаж хил зааг, байршил хэмжээг мэдээллийн санд бүртгэж, ИТХ-аар батлуулсан байна. | | байршил хэмжээг мэдээллийн санд бүртгэж, ИТХ-аар батлуулсан байна | цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах зориулалтаар 20 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хэрэгцээнд хамруулсан. Аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор, 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 70 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газруудын тусгай хамгаалалтад байх хугацааг 15 жилээр сунгах шийдвэр гаргуулан мэдээллийн санд бүртгүүлэн ажиллав. Толбо нуурыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан шийдвэрийг Ашигт малтмал, газрын тосны газарт уламжлан зураг зүйн мэдээллийн сангийн RSPT-03245 дугаарт бүртгүүлсэн. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хар нуур, Ховд голын сав газрын захиргаа, Толбо сумын ЗДТГазрын албан хаагчид хамтран орон нутгийн тусгай хамгаалалтад авсан Толбо нуурын эрэг дагуух 4 тонн хог хаягдлыг цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт буулгаж ажиллав. | 90% |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | **92%** | |
| 6. **Ойн нөөцийг хамгаалах, “Тэрбум мод” хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах** | | | | | | | | |
| 31 | 1 | Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгөөр таримал ой ургуулах ажлыг зохион байгуулж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрыг тусган батлуулах | Орон нутаг, ААНБ-ын төсөв | Суурьшлын бүс орчимд 50000 дээш ширхэг мод ургуулсан байна. | 2021 онд 250064 ширхэг 8 төрлийн мод таригдсан | 100 га талбайг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд батлуулах, 50 га талбайд таримал ой ургуулах ажлыг зохион байгуулсан байх. Бүх нийтээр мод тарих аяныг зохион байгуулж тарьсан модны арчилгаа хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах. 50000 дээш ширхэг мод ургуулсан байна. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 48 дугаар тогтоолоор “Ногоон-Өлгий” дэд хөтөлбөрийг батлуулан ажиллаж байна. 2022 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд орон нутгийн төсөв, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс нийт 546.4 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн болно. Мөн сумдын газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд 729 га талбайг мод тарих, ногоон байгууламж бий болгох, мод үржүүлгийн талбай байгуулах зориулалтаар ашиглуулахаар тусган батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2022 онд аймгийн хэмжээнд нийт 172964 ширхэг 10 төрлийн мод, бут сөөг таригдсан ба нийт 514618.0 мянган төгрөгийн зардал гарсан болно. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | 2 | Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх, үр бэлтгэх байнгын болон түр талбайг байгуулах, арчлах, | Орон нутгийн төсөв | СДО ангийн мод үржүүлгийн газар, үр бэлтгэх 40га талбайд | 2021 онд СДО анги улиас, бургасны 60 мянган ширхэг суулгацыг мөчрөөр бэлтгэсэн | Өлгий сумын мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлнэ. Тарьц, суулгацын нөөцийг 50 хувиар нэмэгдүүлэх | Сум дундын Ойн ангийн үйл ажиллагааг дэмжин, мод үржүүлгийн талбайд ашиглах зориулалтаар трактор, усны цахилгаан насос, бороожуулагчаар хангахаар байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас гаргах 58,5 сая төгрөгийн зарцуулахаар болж худалдан авах ажиллагаанд “ПЖГМ” ХХК шалгарч бараа нийлүүлэх ажлыг хил, гаалийн түр саатал гарсан тул 2023 оны эхний улиралд нийлүүлэхээр гэрээгээ сунгуулсан болно. | 70% |
| 33 | 3 | Ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэх. | Орон нутгийн төсөв | Аймгийн хэмжээнд | 2021 онд | 20 га –д хийгдсэн байх. Урд онуудад хийгдсэн ойжуулалтын ажлын арчилгаа усалгаа хийх | Аймгийн Засаг даргын 2022 оны А/326 тоот захирамжаар "Ногоон-Өлгий" аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хаврын мод тарилтын үеэр 167 аж ахуйн нэгж байгууллага, 5000 гаруй иргэдийн оролцоотойгоор нийт 140000 орчим мод тарьж усалгаа, арчилгаа хийн ургуулсан ба намрын тооллогын дүнгээр 77.1 хувийн ургалттай байна. Намрын мод тарих ажлын хүрээнд 33000 гаруй мод тарьсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд ойн зурвас 10 га, ойжуулалт 30 га газарт тарих ажлыг "Монгол уулын ой" ХХК гүйцэтгэлээ. | 100% |
| 34 | 4 | “Ногоон паспорт-Ногоон төгөл” цэцэрлэгийг орон нутгийн өмчид бүртгэн авах, цаашид өргөжүүлж мод тарих, сургалт зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Ногоон төгөл хашаанд нэмж 2000 ш гоёлын мод таригдана | 2020 онд ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэнд 2500 ширхэг гоёл, жимсний 9 төрлийн мод таригдсан. | 3,0 га –аар өргөжүүлэх | “Ногоон паспорт-Ногоон төгөл” цэцэрлэгийн таригдсан мод болон бараа материалыг орон нутгийн өмчид бүртгэн авсан ба энэ жил нэмж гоёл чимэглэлийн болон жимсний 300 ширхэг мод тарьж ургуулж байна. Мод тарих 1000 сургагч багш бэлтгэх сургалтад тус аймгаас 49 иргэн хамрагдсан. | 100% |
